



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 11 өдөр

Дугаар А/143

Мандалговь

Зохион байгуулалтын арга хэмжээ  
авах тухай,,

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6."а", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Засгийн газрын 2021 оны 45, 91 дүгээр тогтоол, Улсын Онцгой комиссын 2021 оны 02 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 2021 оны 12 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст (КОВИД-19)-ын цар тахал батлагдсантай холбогдуулан 2021 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 14.00 цагаас 2021 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 14.00 цаг хүртэл аймаг сумаас орох, гарах хөдөлгөөнийг хязгаарлаж хяналтын цэгүүдийг нэмэгдүүлж хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газар (М.Адъяабаатар), Цагдаагийн газар (Г.Наранбаатар), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2. Дээрх хугацаанд архи, согтууруулах ундааны зүйлс худалдан борлуулах, түүгээр үйлчлэхийг дээрх хугацаанд хориглож, хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Г.Наранбаатар), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Эмийн сан, өвчтөн хэвтэн эмчлүүлдэг эмнэлэг, шатахуун түгээх станц, ус түгээх цэг, хүнсний үйлдвэрүүдийн үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлж хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газар (Б.Алтантөгс), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат) нарт үүрэг болгосугай.

4. Хүнсний дэлгүүрүүдийн ажиллах цагийн хуваарийг 09.00 цагаас 18.00 цагийн хооронд байхаар тогтоож бусад үйл ажиллагааг хязгаарлаж хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), Цагдаагийн газар (Г.Наранбаатар) нарт даалгасугай.

5. Дээрх хугацаанд албан байгууллага, орон сууцны орц, хүүхдийн тоглоомын талбай зэрэг халдвар тархах эрсдэл бүхий орчны ариутгал халдваргүйтгэл хийж гүйцэтгэх хуваарийг батлуулж ажиллахыг тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллагуудын удирдлагууд, Эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат) нарт тус тус үүрэг болгосугай.

6. Аймгийн төвд хөдөлгөөнд оролцох автомашинуудыг аймгийн Онцгой комиссын шуурхай штабын тусгай зөвшөөрлөөр хөдөлгөөнд оролцуулахыг Онцгой байдлын газар (М.Адъяабаатар)-т үүрэг болгосугай.

7. Эрдэнэдалай, Өндөршил сумдад ажиллах ажлын хэсгийг томилон үүрэг гүйцэтгүүлэхийг Онцгой байдлын газар (М.Адъяабаатар)-т үүрэг болгосугай.

8. Хөл хорио тогтоосон хугацаанд хууль тогтоомжийг мөрдөж, онцын шаардлагагүй бол гэрээсээ гарахгүй байж, мэргэжлийн байгууллагуудын

481210399

зөвлөмжийг хэрэгжүүлэн, халдвар, хамгааллын дэглэмийг баримтлахыг аймгийн нийт иргэдэд уриалсугай.

9. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Анхбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Ц.МӨНХБАТ

